



УВС АЙМАГ
ДАВСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 2/01

Зүүнхөвөө

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит 3 дугаар хуралдааны тов, хэлэлцэх
асуудлын төлөвлөгөө батлах тухай

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 3 дугаар хуралдаан хуралдуулахын тулд Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэхь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 3 дугаар хуралдааныг 2021 оны 01 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд 09.30 цагаас шинэ Соёлын төвийн "Урлаг" зааланд зарлан хуралдуулсугай.

2. Хуралдаанаар дараахи асуудлыг хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай

Ажлын хэсэг

- Сумын Засаг даргын / 2020 -2024 он / үйл ажиллагааны хөтөлбөр батлах
тухай

Ч.Тогтохбаяр – Сумын Засаг дарга

- Төсөвт байгууллагуудын 2020 онд зохиогдсон ажлын гүйцэтгэлийн тайлан,
цаашдын үйл ажиллагаа

Байгууллагын дарга, эрхлэгч нар

ДАРГА  Ц.АМАРТҮВШИН

